ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/358/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Пагамдулам
Утас: 261628 Цахим хаяг:pagamdulamm@audit.gov.mn
Аудитор Б.Отгонцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 12

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 13

4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 19

4.1 Ерөнхий зүйл ..... 19

4.2 Материаллаг байдал ..... 19

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 19

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 20

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 20

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 21

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 21

5.1 Төлбөрийн акт ..... 22

5.2 Албан шаардлага ..... 22

5.3 Зөвлөмж ..... 26

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 27


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХЗДХЯ | Хууль зүй дотоод хэргийн яам |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/303

танай ____________-ны №____________-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ОЧИРБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын аргаас зайлсхийж 172,528.5 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулсан;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 193,517.4 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материал бэлтгэсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвөөс 37,264.9 мянган төгрөгийг зарцуулсан;
- Жилийн эцэст 55,210.4 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3,Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 15.2.7 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 188 дугаар тогтоолоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Засгийн газрын нөөц сангаас 100,000.0 ам.доллартой тэнцэх 357,480.0 мянган төгрөгийг дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хандивласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн "Улаан бурхан өвчний тархалтыг хязгаарлаж, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг улсын хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулах" тухай 08 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 1,742,012.2 мянган төгрөгийн улаан бурхны эсрэг вакцин, тариурыг худалдан авч Халдварт өвчин судлалын үндэсний төвд хуваарилсан байна.

**Бусад асуудал**

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/191 дугаар тушаалаар эрүүл мэндийн яамны 5 хэлтсийг татан буулгаж удирдах 8 албан тушаалтан, гүйцэтгэх 2 албан тушаалтан нийт 10 албан тушаалтныг цомхотгон бүтэц орон тоог 104 байхаар шинэчлэн баталсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **588,766,902.56** | **768,428,208.97** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **33,395,868.24** | **8,131,168.50** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 33,395,868.24 | 8,131,168.50 |
| 31220 | Гадаад валют | 33,395,868.24 | 8,131,168.50 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 33,395,868.24 | - |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | - | 8,131,168.50 |
| **33** | **АВЛАГА** | **186,023,746.81** | **493,520,368.17** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,346,449.00 | 3,776,423.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 71,422,780.66 |
| 33500 | Бусад авлага | 183,677,297.81 | 418,321,164.51 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 183,677,297.81 | 418,321,164.51 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **132,252,192.50** | **15,783,664.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 132,252,192.50 | 15,783,664.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **237,095,095.01** | **250,993,008.30** |
| 35400 | Хангамжийн материал | 237,095,095.01 | 250,993,008.30 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,015,885.00 | 2,937,710.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 58,434,350.00 | 46,475,739.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 27,874,400.00 | 25,355,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,346,014.71 | 2,309,978.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 143,424,445.30 | 173,914,381.30 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,405,964,145.38** | **4,915,407,759.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **6,405,964,145.38** | **4,915,407,759.68** |
| 39200 | Биет хөрөнгө | 3,881,846,952.61 | 3,674,097,078.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,998,322,269.55 | 2,998,322,269.55 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,064,316,204.52) | (1,242,909,343.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 693,937,005.00 | 693,937,005.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (357,734,592.74) | (411,948,293.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 4,147,809,379.75 | 5,611,006,249.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,759,387,076.08) | (4,176,428,582.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 432,747,154.15 | 438,436,286.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (226,955,469.08) | (269,702,838.04) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 39,384,381.47 | 64,209,781.47 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (21,959,894.89) | (30,825,455.03) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 2,524,117,192.77 | 1,241,310,680.89 |
| 39301 | Програм хангамж | 7,125,432,787.49 | 7,125,432,787.49 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,697,905,134.72) | (5,980,711,646.60) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 96,589,540.00 | 96,589,540.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **6,994,731,047.94** | **5,683,835,968.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,396,883,309.30** | **207,076,112.74** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,396,883,309.30** | **207,076,112.74** |
| 41300 | Өглөг | 3,363,487,441.06 | 198,944,944.24 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,487,441.06 | 120,136,604.24 |
| 41360 | Бусад өглөг | 3,362,000,000.00 | 78,808,340.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,360,000,000.00 | 75,419,520.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 2,000,000.00 | 3,388,820.00 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 33,395,868.24 | 8,131,168.50 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 33,395,868.24 | 8,131,168.50 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,597,847,738.64** | **5,476,759,855.91** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,597,847,738.64 | 5,476,759,855.91 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 2,742,600,541.40 | 2,742,600,541.40 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 2,742,600,541.40 | 2,742,600,541.40 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (1,380,215,523.97) | 498,696,593.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,330,196,848.01 | (1,380,215,523.97) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (5,710,412,371.98) | 1,878,912,117.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,235,462,721.21 | 2,235,462,721.21 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **6,994,731,047.94** | **5,683,835,968.65** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *∕төгрөгөөр∕*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **20,251,873,831.51** | **20,180,748,724.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,457,712,621.51** | **20,180,748,724.49** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,457,712,621.51** | **1,001,126,982.08** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,545,497.94 | 3,759,809.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,545,497.94 | 3,759,809.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 566,535,201.52 | 867,261,454.04 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,886,631,922.05 | 130,105,719.04 |
| 122 | Тусламжийн орлого | - | 19,179,621,742.41 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 19,179,621,742.41 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,481,312,883.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 8,481,312,883.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 10,698,308,859.41 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 1,190,300,747.00 |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 9,508,008,112.41 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **16,794,161,210.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **9,302,652,800.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 9,302,652,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,491,508,410.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,151,055,430.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,340,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 452,980.00 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **12,968,481,478.57** | **16,138,619,112.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,968,481,478.57** | **16,138,619,112.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,948,112,902.12** | **14,578,094,000.26** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,048,064,566.00 | 4,288,468,801.51 |
| 210101 | Үндсэн цалин | 2,304,368,306.00 | 2,571,554,865.51 |
| 210102 | Нэмэгдэл | 969,534,860.00 | 875,252,121.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 423,072,000.00 | 511,241,000.00 |
| 210104 | Урамшуулал | 351,089,400.00 | 330,420,815.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 510,701,811.14 | 542,660,879.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 348,042,083.43 | 370,594,473.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 40,946,127.37 | 43,599,349.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 21,130,242.04 | 21,785,770.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 20,116,664.47 | 21,336,257.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 80,466,693.83 | 85,345,027.74 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 106,783,600.00 | 117,218,586.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 51,975,100.00 | 60,671,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,448,300.00 | 42,479,886.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,360,200.00 | 14,066,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 170,365,991.07 | 87,939,632.57 |
| 210401 | Бичиг хэрэг | 38,289,203.34 | 20,515,285.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,334,331.29 | 23,410,165.71 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 37,149,552.44 | 31,430,525.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,316,662.00 | 12,583,656.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 19,276,242.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 200,000.00 | 465,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 465,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,211,400.00 | 25,432,477.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,812,900.00 | 5,178,595.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,398,500.00 | 20,253,882.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 238,309,033.00 | 127,634,425.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210701 | Гадаад албан томилолт | 67,546,080.00 | 29,002,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 170,762,953.00 | 98,632,425.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 929,465,983.46 | 2,139,031,531.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 879,056,953.02 | 2,104,803,331.28 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,128,807.50 | 6,843,520.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 551,301.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 122,000.00 | 83,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,552,791.94 | 11,260,720.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,378,040.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 30,000.00 | 81,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 20,646,090.00 | 15,959,960.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,933,010,517.45 | 7,249,242,666.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,840,823,319.35 | 4,835,618,107.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 372,624,462.54 | 2,943,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,719,562,735.56 | 2,410,681,359.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,020,368,576.45 | 1,560,525,112.19 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 78,591,441.20 | 84,840,087.22 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 3,660,887.22 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 3,660,887.22 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 3,610,567.22 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | - | 50,320.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 78,591,441.20 | 81,179,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,730,026,505.61 | 1,475,685,024.97 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,683,072,505.61 | 899,692,542.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 560,301,082.97 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 46,954,000.00 | 15,691,400.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 211,750,629.64 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 211,297,649.64 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 452,980.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **7,283,392,352.94** | **4,042,129,612.04** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **12,993,804,724.92** | **2,163,217,494.77** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 12,993,804,724.92 | 2,163,217,494.77 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(12,993,804,724.92)** | **(2,163,217,494.77)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **(5,710,412,371.98)** | **1,878,912,117.27** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *|/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **16,876,449,508.12** | **19,220,986,676.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **44,669,129.18** | **19,220,986,676.59** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 44,669,129.18 | 41,339,133.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,273,260.94 | 26,749,965.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,273,260.94 | 26,749,965.00 |
| 120009 | Бусад орлого | 33,395,868.24 | 14,589,168.50 |
| 122 | Тусламжийн орлого | - | 19,179,647,543.09 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 19,179,647,543.09 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгос он саон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,481,312,883.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | - | 8,481,312,883.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 10,698,334,660.09 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 1,190,300,747.00 |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүйнөөцхөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 9,508,033,913.09 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **16,831,780,378.94** | **-** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 9,302,652,800.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 9,302,652,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,529,127,578.94 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,188,674,598.94 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,340,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээндбийболсон нэмэлт орлого | 452,980.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,728,523,834.88** | **19,181,625,176.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,728,523,834.88** | **19,181,625,176.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **14,708,505,258.43** | **17,549,827,283.48** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,116,334,200.62 | 4,321,611,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,292,787,908.62 | 2,155,421,617.38 |
| 210102 | Нэмэгдэл | 1,022,256,334.00 | 1,337,184,895.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 423,219,396.00 | 527,660,500.00 |
| 210104 | Урамшуулал | 378,070,562.00 | 301,344,887.55 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 518,290,187.05 | 564,422,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 342,870,487.69 | 383,789,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 43,773,900.00 | 45,366,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 22,210,899.36 | 22,557,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 21,887,000.00 | 22,541,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 87,547,900.00 | 90,167,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 106,873,200.00 | 107,166,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 51,975,100.00 | 60,671,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 39,232,400.00 | 32,427,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,665,700.00 | 14,066,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 114,160,097.78 | 90,710,413.86 |
| 210401 | Бичиг хэрэг | 37,435,323.34 | 21,011,535.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,406,900.00 | 21,426,615.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 37,179,152.44 | 31,430,425.86 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,138,722.00 | 16,841,838.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,962,000.00 | 1,301,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,962,000.00 | 1,301,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 18,215,698.00 | 55,252,228.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,817,198.00 | 21,158,045.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,398,500.00 | 34,094,183.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 242,089,033.00 | 127,634,425.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 82,614,800.00 | 29,002,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 159,474,233.00 | 98,632,425.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,031,463,686.44 | 545,519,167.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээнийтөлбөр хураамж | 981,253,354.50 | 505,357,184.11 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,905,000.00 | 4,414,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 490,500.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 122,000.00 | 83,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,524,999.94 | 16,887,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 938,700.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 30,000.00 | 81,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 19,199,132.00 | 18,695,883.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,559,117,155.54 | 11,736,208,349.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,175,834,907.00 | 11,733,265,149.51 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 383,282,248.54 | 2,943,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,020,018,576.45** | **1,631,797,892.85** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 78,591,441.20 | 156,262,867.88 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 75,083,667.88 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 75,083,667.88 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийнзардал\\ | - | 3,610,567.22 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогодтооцох төвлөрүүлгийн зардал\\ | - | 50,320.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2131125 | Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | - | 32,610,577.62 |
| 2131126 | Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | - | 38,812,203.04 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 78,591,441.20 | 81,179,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,729,676,505.61 | 1,475,535,024.97 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,683,072,505.61 | 899,542,542.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 560,301,082.97 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 46,604,000.00 | 15,691,400.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 211,750,629.64 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 211,297,649.64 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 452,980.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **147,925,673.24** | **39,361,500.26** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **114,529,805.00** | **64,626,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **114,529,805.00** | **64,626,200.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 114,529,805.00 | 64,626,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 114,529,805.00 | 64,626,200.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(114,529,805.00)** | **(64,626,200.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **33,395,868.24** | **(25,264,699.74)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 33,395,868.24 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 33,395,868.24 | 8,131,168.50 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,742,600,541.40** | **2,235,462,721.21** | **4,703,266,990.17** | **9,681,330,252.78** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (373,070,142.16) | (373,070,142.16) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,742,600,541.40 | 2,235,462,721.21 | 4,330,196,848.01 | 9,308,260,110.62 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (5,710,412,371.98) | (5,710,412,371.98) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,742,600,541.40** | **2,235,462,721.21** | **(1,380,215,523.97)** | **3,597,847,738.64** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,742,600,541.40 | 2,235,462,721.21 | (1,380,215,523.97) | 3,597,847,738.64 |
| **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **1,878,912,117.27** | **1,878,912,117.27** |
| **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **2,742,600,541.40** | **2,235,462,721.21** | **498,696,593.30** | **5,476,759,855.91** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **8,740,924,900.00** | **8,504,452,280.78** | **236,472,619.22** | **97.3** |
| 12 | Татварын бус орлого | 8,740,924,900.00 | 8,504,452,280.78 | 236,472,619.22 | 97.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,500,000.00 | 26,749,965.00 | (21,249,965.00) | 486.4 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 5,500,000.00 | 26,749,965.00 | (21,249,965.00) | 486.4 |
| 122 | Тусламжийн орлого | 8,735,424,900.00 | 8,477,702,315.78 | 257,722,584.22 | 97.0 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 8,735,424,900.00 | 8,477,702,315.78 | 257,722,584.22 | 97.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,740,924,900.00** | **8,471,841,703.16** | **269,083,196.84** | **96.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,740,924,900.00** | **8,471,841,703.16** | **269,083,196.84** | **96.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,183,588,300.00** | **6,915,127,478.19** | **268,460,821.81** | **96.3** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,453,745,500.00 | 4,321,611,900.00 | 132,133,600.00 | 97.0 |
| 210101 | Үндсэн цалин | 2,194,362,900.00 | 2,155,421,617.38 | 38,941,282.62 | 98.2 |
| 210102 | Нэмэгдэл | 1,637,197,500.00 | 1,337,184,895.07 | 300,012,604.93 | 81.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 416,230,400.00 | 527,660,500.00 | (111,430,100.00) | 126.8 |
| 210104 | Урамшуулал | 205,954,700.00 | 301,344,887.55 | (95,390,187.55) | 146.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 564,422,900.00 | 564,422,900.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 383,789,700.00 | 383,789,700.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 45,366,600.00 | 45,366,600.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,557,800.00 | 22,557,800.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 22,541,800.00 | 22,541,800.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 90,167,000.00 | 90,167,000.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 107,166,100.00 | 107,166,100.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 60,671,800.00 | 60,671,800.00 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 32,427,400.00 | 32,427,400.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,066,900.00 | 14,066,900.00 | - | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 106,617,800.00 | 90,710,413.86 | 15,907,386.14 | 85.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,572,800.00 | 21,011,535.00 | 3,561,265.00 | 85.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,352,900.00 | 21,426,615.00 | 3,926,285.00 | 84.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 38,466,000.00 | 31,430,425.86 | 7,035,574.14 | 81.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,226,100.00 | 16,841,838.00 | 1,384,262.00 | 92.4 |
| 2105 | Нормативт зардал | 1,762,900.00 | 1,301,800.00 | 461,100.00 | 73.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,762,900.00 | 1,301,800.00 | 461,100.00 | 73.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 65,081,000.00 | 56,277,128.00 | 8,803,872.00 | 86.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,226,000.00 | 21,158,045.00 | 67,955.00 | 99.7 |
| 210604 | Урсгал засвар | 43,855,000.00 | 35,119,083.00 | 8,735,917.00 | 80.1 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 127,679,100.00 | 127,634,425.00 | 44,675.00 | 100.0 |
| 210701 | Гадаад албан томилолт | 29,002,000.00 | 29,002,000.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 98,677,100.00 | 98,632,425.00 | 44,675.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 655,480,600.00 | 568,181,067.11 | 87,299,532.89 | 86.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 608,678,900.00 | 526,719,184.11 | 81,959,715.89 | 86.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,414,500.00 | 4,414,500.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 439,400.00 | - | 439,400.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 175,900.00 | 83,000.00 | 92,900.00 | 47.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,020,300.00 | 18,187,500.00 | 3,832,800.00 | 82.6 |
| 210807 | Газрын төлбөр | 878,900.00 | - | 878,900.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 175,800.00 | 81,000.00 | 94,800.00 | 46.1 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,696,900.00 | 18,695,883.00 | 1,017.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,101,632,400.00 | 1,077,821,744.22 | 23,810,655.78 | 97.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,098,689,200.00 | 1,074,878,544.22 | 23,810,655.78 | 97.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,943,200.00 | 2,943,200.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,557,336,600.00** | **1,556,714,224.97** | **622,375.03** | **100.0** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 81,179,200.00 | 81,179,200.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 81,179,200.00 | 81,179,200.00 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,476,157,400.00 | 1,475,535,024.97 | 622,375.03 | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 899,942,800.00 | 899,542,542.00 | 400,258.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 560,523,200.00 | 560,301,082.97 | 222,117.03 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,691,400.00 | 15,691,400.00 | - | 100.0 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **32,610,577.62** | **(32,610,577.62)** | |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **(32,610,577.62)** | **32,610,577.62** | |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (32,610,577.62) | 32,610,577.62 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **212.00** | **115.00** | **97.00** | **54.2** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **-** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **104.00** | **-** | **104.00** | **-** |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | - | 7.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 96.00 | - | 96.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.00 | - | 1.00 | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **96.00** | **104.00** | **(8.00)** | **108.3** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 91.00 | 94.00 | (3.00) | 103.3 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 5.00 | (2.00) | 166.7 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 2.00 | 5.00 | (3.00) | 250.0 |
| **66** | **НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ** | **11.00** | **10.00** | **1.00** | **90.9** |
| 660001 | Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 11.00 | 10.00 | 1.00 | 90.9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **10,698,334,660.09** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,698,334,660.09** |
| 122 | Тусламжийн орлого | 10,698,334,660.09 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 10,698,334,660.09 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,698,334,660.09 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,190,300,747.00 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,508,033,913.09 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,665,930,137.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,665,930,137.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,665,930,137.05** |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,665,930,137.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,665,930,137.05 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **32,404,523.04** |
| **5** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **(32,404,523.04)** |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (32,404,523.04) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт хүргэж, амьдралын чанарыг нь сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх салбарын оновчтой, чадварлаг бүтцийг бүрдүүлж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;
- Нээлттэй, ил тод, шуурхай үйлчилгээ үзүүлэх,

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн яам нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн салбарын бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас эрүүл мэндийн яамны аппаратын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/590 дүгээр тушаалаар баталсан НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,319,026.2 мянган төгрөгөөр буюу 18.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 33,395.9 | 8,131.2 | (25,264.7) |
| Авлага | 186,023.7 | 493,520.4 | 307,496.7 |
| Урьдчилгаа | 132,252.2 | 15,783.7 | (116,468.5) |
| Бараа материал | 237,095.1 | 250,993.0 | 13,897.9 |
| Үндсэн хөрөнгө | 6,405,964.1 | 4,915,407.8 | (1,490,556.3) |
| Нийт хөрөнгө | 6,994,731.0 | 5,675,704.8 | (1,319,026.2) |
| Өр төлбөр | 3,396,883.3 | 207,076.1 | (3,189,807.2) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,742,600.5 | 2,742,600.5 | - |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 6,994,731.0 | 5,675,704.8 | (1,319,026.2) |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 8,131.2 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 25,264.7 мянган төгрөгөөр буурахад гадаад валютын хөрвүүлгийн дансанд бүртгэлтэй эзэн холбогдогч тодорхойгүй 33,395.9 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгох төлбөрийн актын дагуу төсөвт төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэл 493,520.4 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 307,496.6 мянган төгрөгөөр өсөхөд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Идэр чийрэг-Монгол цэрэг дэд төслийг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/423 дугаар тушаалаар цэрэг татлагын үеийн үзлэгийг чанаржуулах, оношлуураар хангахтай холбоотой 250,000.0 мянган төгрөгийг Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвд шилжүүлсэн, мөн сангийн яаманд төвлөрүүлсэн 71,422.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагаар нэмэгдэж, удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд Шүүхийн шийдвэрийн дагуу олгосон 20,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 15,783.7 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 116,468.5 мянган төгрөгөөр буурахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 6 дүүргийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах 115,044.0 мянган төгрөгийн сургалт зохион байгуулагдсан нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 250,993.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 13,897.7 мянган төгрөгөөр өсөхөд, худалдан авсан 2,220,582.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 464,639.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/525 дугаар тушаалаар Халдварт өвчин судлалын үндэсний төвд хуваарилсан 1,742,045.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал хасагдсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан 67,825.2 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 16 дугаар тогтоолоор Хилийн боомтын захиргаанаас 1,189,963.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 222 дугаар тогтоолоор Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх төслөөс 29,900.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 299 дүгээр тогтоолоор

Монгол Улсад ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслөөс 207,798.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг тус тус балансаас балансад шилжүүлж, ЭМС-ын А/482 дугаар тушаалаар дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 30,340.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны А-1/2308 дугаар албан бичгээр 32,116.2 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг данс хооронд шилжүүлсэн, элэгдлийн зардал 3,001,422.3 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 207,076.1 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 3,189,807.2 мянган төгрөгөөр буурахад Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолын дагуу сумдын эрүүл мэндийн төвд эмнэлгийн зориулалттай, туулах чадвар сайтай 60 автомашин худалдан авсны үлдэгдэл төлбөр 3,360,000.0 мянган төгрөгийг Таван богд ХХК-д төлсөн нь голлон нөлөөлсөн байна.

*Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:*

Байгууллагын үйл ажиллагаанд нийт 6,845,216.4 мянган төгрөгийн 20 программ хангамжийг ашигладаг бөгөөд тайлант онд систем хөгжүүлэлт, лицензийн төлбөрт 11,052.0 мянган төгрөгийг төлсөн байна. Тухайлбал: Нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программын лицензийн төлбөрт 1,782.0 мянган төгрөг, Dynamic программын лицензийн төлбөрт 1,320.0 мянган төгрөг, дотоод аудитын удирдлагын цогц систем Абле программын лицензийн төлбөрт 7,950.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,904,629.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зарлагыг 9,910,129.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,012,300.0 мянган төгрөг, Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 45,255.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 109,541.6 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 166,791.6 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 268,762.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 623,171.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 353,226.1 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 42,880.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 25,403,310.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоо мэдээг үндэслэн судалгаа, тооцоолол хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 16,662,385.9 мянган төгрөгөөр бууруулж, нийт 10 удаа тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,735,424.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,445,091.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 26,749.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,471,841.7 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 184,397.3 мянган төгрөг, байр ашиглалтын үйлчилгээний зардлыг 68,156.2 мянган төгрөг, Ахмад дайчин, алдар цолтоны зардлыг 400.3 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зардлыг 15,906.4 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 222.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71603** | **Эрүүл мэндийн бодлого удирдлага** | **8,740,924.9** | **8,471,841.7** | **269,083.2** | **96.9** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 6,494,111.6 | 6,309,714.3 | 184,397.3 | 97.2 |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 384,028.2 | 315,872.0 | 68,156.2 | 82.3 |
| 80509 | ОУБ-ын гишүүнчлэл хураамж | 81,179.2 | 81,179.2 | - | 100.0 |
| 80704 | Ахмад дайчин, алдар цолтон | 899,942.8 | 899,542.5 | 400.3 | 100.0 |
| 80725 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ | 55,807.7 | 39,901.3 | 15,906.4 | 71.5 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 576,214.6 | 575,992.5 | 222.1 | 100.0 |
| 81560 | Улаан загалмай нийгэмлэгээр гүйцэтгүүлэх | 24,426.4 | 24,426.4 | - | 100.0 |
| 81563 | Цахим бодлогын арга хэмжээ | 68,032.9 | 68,032.9 | - | 100.0 |
| 81569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 157,181.5 | 157,181.5 | - | 100.0 |

1. *Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:*

Тус байгууллагын орон тоог 114 байхаар баталж 4,730,723.0 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/191 дугаар тушаалаар 5 хэлтсийг татан буулгаж орон тоог 9 хувиар бууруулж 104 орон тоотой байхаар баталж гүйцэтгэлээр 409,111.1 мянган төгрөгийн цалингийн зардлыг хэмнэсэн байна.

2. *Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар*:

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/87 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны зардалыг 34.0 мянган төгрөг, унааны зардалыг 3.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож тайлант хугацаанд хоолны зардалд 464,026.0 мянган төгрөг, унааны зардалд 46,775.0 мянган төгрөг нийт 510,801.0 мянган төгрөгийг олгосон байна.

3. *Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн:*

Тайлант онд Монгол Улсын ерөнхийлөгчийн Бүгд найрамдах Чех улс болон Бүгд найрамдах польш улсад хийх албан ёсны айлчлалын хүрээнд гадаад томилолтод 29,002.0 мянган төгрөгийг төсөв баталж – зарцуулсан байна.

Гадаад томилолтын арга хэмжээнд төлөвлөөгүй нийт 130,588.5 мянган төгрөгийн зардлыг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж гадаад томилолтын арга хэмжээнд зарцуулсанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4. *Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:*

Удирдлагын академиас зохион байгуулдаг Ёс зүйн хорооны гишүүдийн сургалтад 3 албан хаагчийг сургахтай холбоотой 1 арга хэмжээнд 2,943.2 мянган төгрөгийн сургалтын зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 5 арга хэмжээнд 14,536.0 мянган төгрөгийг зарцуулсан. Үүнээс бараа үйлчилгээний бусад зардлаас 4 арга хэмжээнд 11,592.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

5. *Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүн:*

Тайлант онд 8 аж ахуйн нэгж, 1 хувь хүнтэй нийт 87,070.0 мянган төгрөгийн хэвлэл мэдээлэл, видео контент бэлтгэх гэрээ байгуулж, гүйцэтгэлээр бараа үйлчилгээний бусад зардлаас 77,170.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 9,900.0 мянган төгрөг зарцуулсан байна. Хэвлэл мэдээллийн зардалтай холбоотой гарсан зөрчлийг тайланд тусгаж албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

6. *Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны үр дүн:*

Удирдлагын буруу шийдвэрээр 2023-2024 онуудад ажлаас халагдсан нийт 8 албан тушаалтанд Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс 248,311.5 мянган төгрөгийг олгосон бөгөөд тайлант онд 48,111.7 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, 20,000.0 мянган төгрөгийг ХЗДХЯ-ны төсвөөс төлж, үлдэгдэл 180,199.7 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 786,875.4 мянган төгрөг, Засгийн газрын нөөц сангаас тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 9,508,033.9 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс 403,375.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 50.3 мянган төгрөг, нийт 10,698,334.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 10,659,472.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 38,862.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Эрүүл мэндийн яамны нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 19 төсөл арга хэмжээнд зориулж 754,470.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 19 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт* /мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний зохицуулалт, хариу арга хэмжээг бэхжүүлэх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах | 2025 он | Эрүүл мэндийн байгууллагуудад гэр бүл төлөвлөлтйин тусламж, үйлчилгээг ард иргэдэд жигд, хүртээмжтэй хүргэж, тандалтын тогтолцоонд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн тооцооллыг бүрэн нэвтрүүлэх | 100 хувь | 5,022,000.0 | 5,022,000.0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Олон улсын эх баригчдын өдрийг тэмдэглэх | 2025 он | Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050-д тусгагдсан сэргийлж болох эх нярайн эндэгдлэлийг бууруулах, гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ болон охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг тэглэх, гамшгийн үеийн эх, нярайн тусламжүйлчилгээнд эх баригчдын гүйцэтгэх үүрэг, оролцоо, мэргэжлийн бие даасан байдал, эх баригчаар гүйцэтгүүлэх тусламжийг өргөжүүлэх, эх баригчидын дуу хоолойг шийдвэр гаргагч нарт хүргэх, ажил мэргэжлийн онцлог, ололт амжилтыг олон нийтэд сурталчлан таниулахад оршино. | 100 хувь | 22,436,000.0 | 22,436,000.0 |
| 3 | Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины болон умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эмч мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах | 2024 он | хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины болон УХХХ-ын эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр эмч, мэргэжилтэн нарын мэдлэг нэмэгдэн, орон нутагт сургагч багш бэлтгэгдсэн байна. | 100 хувь | 185,935,000.0 | 185,935,000.0 |
| 4 | Алсын зайн оношлогооны тусламж, үйлчилгээний журам боловсруулах | 2025 он | Телемедицины журам боловсруулж Эрүүл мэндийн сайдын тушаал батлуулах | 100 хувь | 4,100,000.0 | 4,100,000.0 |
| 5 | Гамшгийн үед иргэдэд үзүүлэх бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжржлах нь сэдэвт сургалт зохион байгуулах | 2025 он | Баруун бүсийн эмч, мэгэжилтэн, анха шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын албан хаагдыг гамшгийн үед бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд үзүүлж, хариу арга хэмжээг зохион байгуулах арга зүйд сургах | 100 хувь | 33,277,600.0 | 33,277,600.0 |
| 6 | Эрүүл мэндийн байгууллагын хэвлэл, мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлч нартай дархлаажуулалтын чиглэлээр уулзалт зохион байгуулах | 2025 он | Аймаг нийслэлийн болон Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, хэвлэл, мэдээллийн ажилтан болоод сэтгүүлчид дархлаажуулалтын талаар албан ёсны нэг мэдээлэлтэй болж иргэд олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээгээр хангаснаар хүний паппиломи вирусийн халдварын эсрэг вакцинжуулалт болон бусад товлолын дархлаажуулалтын харалт нэмэгдэнэ. | 100 хувь | 74,631,200.0 | 74,631,200.0 |
| 7 | Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих нотолгоонд суурилсан, мэдээлэл харицааны стратеги боловсруулах | 2025 он | Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих нотолгоонд суурилсан мэдээлэл харилцааны стратеги боловсруулагдсан байна | 100 хувь | 4,655,000.0 | 4,655,000.0 |
| 8 | Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулах | 2025 он | Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд 2025-2028 онд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна. | 100 хувь | 14,727,000.0 | 14,727,000.0 |
| 9 | Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамын хэрэгжилтийг эрчимжүүлэх | 2025 он | Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамыг хэрэгжүүлэх, зөвлөгөө өгөх, хөхүүл эхийн хөхний арчилгаа хийх чадвартай эрүүл мэндийн ажилтнууд нэмэгдэнэ. | 100 хувь | 28,264,400.0 | 28,264,400.0 |
| 10 | Эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах нь зөвлөлдөх уулзалт зохион байгуулах | 2025 он | Аймаг дүүргийн эрүүл мэндийн ажилтнуудад хоол, шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хэрэгцээ шаардлагыг эрчимжүүлэх | 100 хувь | 70,882,400.0 | 70,882,400.0 |
| 11 | Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх сургагч | 2025 он | Шинэчлэгдсэн 3 төрлийн номыг сургагч багш нарт танилцуулах сургалт зохион байгуулагдсан байна. | 100 хувь | 21, 025,000 | 21, 025,000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | багш нарт давтан сургалт зохион байгуулах | | | | | |
| 12 | Сонгогдсон 5 аймагт монпэн санаачлагыг нэврүүлж, хэрэгжүүлэх арга зүй, эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг чадавхжуулах | 2025 он | Сонгогдсон 5 аймагийн АШЭМБ-дад ХБӨ/ЗСӨ-ний урьчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц PEN/HEARTS нэвтрүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулагдсан байна. | 100 хувь | 142,999,220.0 | 142,999,220.0 |
| 13 | Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад агаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох | 2025 он | Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуульд сурч буй хүүхдүүд агаарын хий мэдрэгч төхөөрөмжийн талаар мэдлэгтэй болж агаарын хийн хордлогоос өөрийгөө болон гэр бүлийхнийгээ хэрхэн урьдчилан сэргийлэх талаар суралцаж, хүүхдээр дамжуулан иргэдийг зөв дадал, хэвшилд сургаснаар агаарын хийн хордлогод өртөх иргэдийн тоо буурна. | 100 хувь | 37,895,500.0 | 37,895,500.0 |
| 14 | Монгол улс дахь хараагы хугарлын гажигийн үеийн тусламж, үйлчилгээний өнөөгий нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх | 2025 он | Монгол улс дахь хараагы хугарлын гажигийн үеийн тусламж, үйлчилгээний өнөөгий нөхцөл байдлын тогтолцоонд суурилсан дүн шинжилгээний мэдээлэлтэй болж, цаашид авах хэмжээний санал, зөвлөмж боловсруулагдсан байна. | 100 хувь | 27,895,600.0 | 27,895,600.0 |
| 15 | Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл монгол хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2025-2028 оны төслийг боловсруулах | 2025 он | Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах "Эрүүл монгол хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2025-2028 оны төслийг боловсруулж, батлуулсан байна. | 100 хувь | 27,913,000.0 | 27,913,000.0 |
| 16 | Дутуу төрөлт: Сэргийлэлт ба дутуу нярайн менежментийн шилдэг туршлага сэдэвт олон улсын сургалт семинар зохион байгуулах | 2025 он | Дутуу төрөлт, нярай хүүхдүүдэд тусламж үзүүлдэг эмч нарын мэдлэг, ур чадвар дээшилнэ | 100 хувь | 50,345,600.0 | 50,345,600.0 |
| 17 | Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх | 2025 он | Монгол улсын эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар нэгдсэн үнэн зөв мэдээллээр хангагдсанаар эх, хүүхэд бүр эсэн мэнд амаржиж эрүүл ирээдүйд тэмүүлнэ. | 100 хувь | 20,846,000.0 | 20,846,000.0 |
| 18 | Орчны эрүүл мэнд 2025-2028 арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | 2025 он | Орчны эрүүл мэнд 2025-2028 арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, хэрэгжиж эхэлсэн байна. | 100 хувь | 14,230,000.0 | 14,230,000.0 |
| 19 | Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулах | 2025 он | Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулж сайдын тушаалаар батлуулсан байна. | 100 хувь | 12,783,600.0 | 12,783,600.0 |
| **Нийт дүн** | | | | **-** | **754,470,903.9** | **754,470,903.9** |

## 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажлын төлөвлөгөөнд 165,280.0 мянган төгрөгийн 11 арга хэмжээг шууд худалдан авахаар баталсны дагуу 165,280.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээ бүртгэхгүй байх, зардлын ангилал зөрчиж зарцуулахгүй байх зэрэг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Б.Отгонцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, дараагийн шатны хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 2/372 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,968,481.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 129,684.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн яам нь тайлант онд цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг 10,596.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.Тус байгууллага нь 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр "Саград" ХХК-иас "Дотоод аудитын мэргэжлийн нэр томьёоны тайлбар толь" ном 50 ширхэг, "Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ" ном 50 ширхэг, нийт 100 ширхэг номыг 4,480.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь зарцуулаагүй үлдэгдлээр бүртгэлтэй бөгөөд хэрэгцээгүй бараа материалын нөөц үүсгэсэн байна

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийг хэмнэлттэй зарцуулж, хэрэгцээ шаардлагагүй бараа материал бэлтгэхгүй байх зөвлөмж өглөө.

2.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал сэдэвт сургалтыг 8 сарын 15, 16-ны өдрүүдэд 80 албан хаагчийг хамруулан "Баянгол ресорт"-д зохион байгуулж сургалт болон хоол, танхимын түрээсийн зардалд нийт 30,475.4 мянган төгрөг, хувь хүнээр их цэвэрлэгээ хийлгэхэд 350.0 мянган төгрөг, төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулахад 6,439.5 мянган төгрөгийн хоолны зардал, төлж төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хязгаарлалтыг хэрэгжүүлээгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 149,116.6 мянган төгрөгийн зөрчлөөс 128,228.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 20,888.1 мянган төгрөгийн 1 зөрчлийг дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулахаар шийдвэрлэлээ.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 128,228.5 мянган төгрөгийн 7 мэдээлэл, мөн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцээгүй.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 2,222,629.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн аудитаар дахин үнэлж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,380.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 729,490.2 мянган төгрөгийн 9 албан шаардлага, 2,859,817.9 мянган төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлага, 209,287.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс 252,600.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 206,867.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, биелэлт 91.9 хувьтай байна. Үүнд:

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 16,380.00 | 2 | 16,380.00 | 100.0 |
| Албан шаардлага | 9 | 729,490.43 | 7 | 544,625.71 | 84.6 |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | 2,859,817.99 | 1 | 2,859,817.99 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 214,826.25 | 2 | 107,958.50 | 82.8 |
| **Нийт дүн** | **15** | **3,820,514.67** | **12** | **3,528,782.20** | **91.9** |

Он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авах болон зардлын ангилал зөрчиж зарцуулсан 2 албан шаардлага, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, төсвийг үр дүнтэй зарцуулах 1 зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдсан тул 22,485.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 193,517.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 180,766.1 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах.
2. Төрийн үйлчилгээний албан хаагчдад сар бүр 10.0-25.0 хувиар ур чадварын нэмэгдлийг бодож, нийт 20,888.1 мянган төгрөгийг олгосон бөгөөд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг батласан эсэхийг шалгаж үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,311,009.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,311,009.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагыг дэлгэрэнгүй бүртгэлээс 833,820.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэр төрлийн тавилга тоног төхөөрөмжийн элэгдлийг зардлыг 1,265.4 мянган төгрөгөөр илүү тооцсон;
- Авлагын дансанд бүртгэлтэй 290.9 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 8,435.9 мянган төгрөг нийт 8,726.7 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй өмнөх үеийн үр дүнд хааж буруу бичилт хийсэн;
- Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 18,942.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 2,375.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний нэмэлт санхүүжилтийн орлогыг 403,375.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвөөс худалдан авсан 21,367.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор буруу бүртгэсэн.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 890,307.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 26,594.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 180,766.1 мянган төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлага, 627,563.0 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 55,383.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 890,307.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 760,622.3 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1.Жилийн эцэст 51,210.4 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Үүнээс он дамжсан Хүннү эйр ХХК-д урьдчилж төлсөн 17,735.3 мянган төгрөг, Өдөр тутмын сонины сэтгүүлчдийн төлбөө ТББ-д хэвлэл мэдээллийн зардлын урьдчилгаанд төлсөн 4,750.0 мянган төгрөг, нийт 22,485.3 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцээгүй байна

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Хүннү эйр ХХК-аар 17,735.3 мянган төгрөг, Өдөр тутмын сонины сэтгүүлчдийн төлөө төрийн бус байгууллагаар 4,750.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Тус яамны балансад бүртгэлгүй Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслийн 09-83 УКМ улсын дугаартай Toyota Land Cruiser-200 маркын автомашины тос масло солиход 509.6 мянган төгрөг, шинээр камер суурилуулж хөгжим солиход 3,600.0 мянган төгрөг, нийт 4,109.6 мянган төгрөгийг зарцуулж, байгууллагын үйл ажиллагаанд явсан баримт байхгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.1.6-д "сахилга баттай байх" гэж тус тус заасантай нийцээгүй

> <u>Шийдвэрлэсэн нь:</u> Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслөөр 4,109.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов

### 5.2 Албан шаардлага

1. ЭМЯ-ны бүтэц орон тоонд байхгүй "сайдын ажлын албаны дарга" гэсэн албан тушаалд хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, тайлант онд нийт 17,658.8 мянган төгрөгийн цалин хөлсийг ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй 2 хүнд олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах; Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дах хэсэгт "Монгол Улсын сайд өөрийн ажлын хэсэгтэй байж болно. Сайдын эрхлэх ажлын хүрээн дэх чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд сайдад зөвлөх үүрэгтэй сайдын зөвлөл ажиллана, сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам, сайдын ажлын хэсгийн орон тооны хязгаар, зардлын төсвийг Засгийн газар тогтооно, "Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ны өдөр баталсан "Сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийн тухай" 66 дугаар тогтоолын 1-д "Монгол Улсын сайдын ажлын хэсэг нь сайдын зөвлөх, сайдын туслах, сайдын хэвлэлийн төлөөлөгч гэсэн 3-аас дээшгүй орон тоотой байхаар тогтоосугай" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоонд байхгүй албан тушаалд хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, цалинжуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/67 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгүүлсэн үндэслэлээр санхүүгийн 9 албан хаагчид, нийт 22,352.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

3.Эх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах чиглэлээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад 43,000.0 мянган төгрөг, Хүний папиллома вирусийн халдварын эсрэг умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахад 23,000.0 мянган төгрөг, Сувилагч тандаа баярлалаа" арга хэмжээний ажлын заал зохион байгуулалт, тайз засалтын арга хэмжээнд 109,528.5 мянган төгрөг, нийт 172,528.5 мянган төгрөгийг 8 компанитай шууд гэрээ байгуулж харьцуулалтын аргаас зайлсхийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.1.1-д "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан"; Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа ажил үйлчилгээг хэсэгчлэн хувааж, харьцуулалтын аргаас зайлсхийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.Тайлант онд сошиал медиа контент, подкаст, рийлс дүрс бичлэг хийлгэхээр "Лаён шийлд" ХХК-тай 6.600.0 мянган төгрөг, Монголын бизнес мэдээллийн судалгааны төвтэй 4,900.0 мянган төгрөг, Эко фокус ХХК-тай 4,900.0 мянган төгрөг, нийт 16,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээг дүгнэж акт үйлдээгүй, тайлангүй мөн Их тэнгэр ХХК-тай гэрээ байгуулаагүй 5,000.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41.2.6-д төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Ажлын тайлангүй, гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгодог зөрчлийг таслан зогоох албан шаардлага хүргүүлэв.

5. Ворлд гарден ХХК-тай 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр "бичиг хэргийн багц" худалдан авахаар 14,000.0 мянган төгрөгийн №13 дугаартай гэрээг байгуулж, хүнсний бүтээгдэхүүн авсан боловч бараа материалын дансанд бичиг хэргийн багц нэрээр орлогод авч, 14 ажилтанд олгосноор баримт бүрдүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6.Тус байгууллага тайлант хугацаанд үйл ажиллагаанд зарцуулсан 141,591.2 мянган төгрөгийн бараа материалыг олгохдоо шаардах хуудсанд ахлах нягтлан бодогч, няравын гарын үсэг зурснаар зарлагдаж, санхүүгийн албаны дарга гарын үсэг зурж зөвшөөрөл олгохгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шаардах хуудсанд дээд шатны удирдлагын зөвшөөрөлгүйгээр бараа материал олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

7.Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн ажилтан жолооч Б.Болдбаатартай сарын 1,500.0 мянган төгрөгийн хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, жолоочоор ажиллуулж 1-6 сард нийт 7,249.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

8.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 48,205.2 мянган төгрөгийн хөрөнгө, 145,312.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусаагүй хөрөнгө, бараа материал бэлтгэж өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

9. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал сэдэвт сургалтыг 8 сарын 15, 16-ны өдрүүдэд 80 албан хаагчийг хамруулан "Баянгол ресорт"-д зохион байгуулж сургалт болон хоол, танхимын түрээсийн зардалд, нийт 30,475.4 мянган төгрөг, хувь хүнээр их цэвэрлэгээ хийлгэхэд 350.0 мянган төгрөг, төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулахад 6,439.5 мянган төгрөгийн хоолны зардал, төлж төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

**Сахилгын шийтгэл**

Гэрэл цахилгааны зардлаас 4,944.0 мянган төгрөгийн өрөөний засварын зардал, Тээвэр шатахууны зардлаас 428.0 мянган төгрөгийн тийзний төлбөр, 935.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардал, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 200.0 мянган төгрөгийн цайны зардал, багаж техник хэрэгслийн зардлаас 14,800.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, урсгал засварын зардлаас 2,000.0, мянган төгрөгийн бичиг хэрэг, 1,961.4 мянган төгрөгийн хэвлэлийн зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 58,840.9 мянган төгрөгийн байр ашиглалтын төлбөр, мэдээлэл технолгийн үйлчилгээний зөрдлаас 360.0 мянган төгрөгийн бараа, 1,000.0 мянган төгрөгийн уулзалтын зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас 17,200.0 мянган төгрөгийн татварын зардал, 37,523.6 мянган төгрөгийн байр ашиглалтын зардал, 40,573.2 сая төгрөгийг бусад зардалд тус тус зардлын ангилал зөрчиж зарцуулж өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж,тайлагнах” Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулан бодитой төлөвлөөгүй, батлагдсан төсвийн ангилал зөрчиж зарцуулсан зөрчлийг давтан гаргасан Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн Р.Содном цэрэнд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Бараа материалын данстай холбоотой асуудал

*<u>1.1 Илрүүлэлт</u>*

Тус байгууллага нь 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр "Саград" ХХК-иас "Дотоод аудитын мэргэжлийн нэр томьёоны тайлбар толь" ном 50 ширхэг, "Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ" ном 50 ширхэг, нийт 100 ширхэг номыг 4,480.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь зарцуулагдаагүй үлдэгдлээр бүртгэлтэй бөгөөд хэрэгцээгүй бараа материалын нөөц үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, хэрэгцээ шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэхгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

*<u>2.1.Илрүүлэлт:</u>*

Тайлант онд зам ашигласны төлбөр, шуудан холбоо утасны төлбөр зэрэг нийт 50,903.1 мянган төгрөгийг өглөг, авлагын тооцоо үүсгэлгүй, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Харилцагч байгууллагатай, өглөг, авлагын тооцоо үүсгэж, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагыг дэлгэрэнгүй бүртгэлээс 833,820.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 833,820.6 | | | 1 | 833,820.6 | 1 | 833,820.6 | | | | |
| 2 | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэр төрлийн тавилга тоног төхөөрөмжийн элэгдлийг зардлыг 1,265.4 мянган төгрөгөөр илүү тооцсон | 1 | 1,265.4 | | | 1 | 1,265.4 | 1 | 1,265.4 | | | | |
| 3 | Авлагын дансанд бүртгэлтэй 290.9 мянган төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 8,435.9 мянган төгрөг нийт 8,726.7 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй өмнөх үеийн үр дүнд хааж буруу бичилт хийсэн. | 1 | 8,726.7 | | | 1 | 8,726.7 | 1 | 8,726.7 | | | | |
| 4 | Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 18,942.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. | 1 | 18,942.0 | | | 1 | 18,942.0 | 1 | 18,942.0 | | | | |
| 5 | Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 2,375.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 23,512.9 | 1 | 23,512.9 | | | 1 | 23,512.9 | | | | |
| 6 | Мөнгөн гүйлгээний нэмэлт санхүүжилтийн орлогыг 403,375.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 403,375.0 | 1 | 403,375.0 | | | 1 | 403,375.0 | | | | |
| 7 | Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвөөс худалдан авсан 21,367.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор буруу бүртгэсэн | 1 | 21,367.0 | | | 1 | 21,367.0 | 1 | 21,367.0 | | | | |
| **Нийт дүн** | | **7** | **1,311,009.7** | **2.0** | **426,887.9** | **5** | **884,121.7** | **7.0** | **1,311,009.7** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Дүн | тоо | Дүн |
| 1 | ЭМЯ-ны бүтэц орон тоонд байхгүй "сайдын ажлын албаны дарга" гэсэн албан тушаалд хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж тайлант онд нийт 17,658.8 мянган төгрөгийн цалин хөлсийг ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй 2 хүнд олгосон. | 1 | 17,658.9 | | | 1 | 17,658.9 | | | | | | | |
| 2 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/67 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгүүлсэн үндэслэлээр санхүүгийн 9 албан хаагчид нийт 22,352.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна. | 1 | 22,352.6 | | | 1 | 22,352.6 | | | | | | | |
| 3 | Тайлант онд зам ашигласны төлбөр, шуудан холбоо утасны төлбөр зэрэг нийт 50,903.1 мянган төгрөгийг өглөг, авлагын тооцоо үүсгэлгүй харилцах данснаас шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | 1 | 50,903.1 | | | | | 1 | 50,903.1 | | | | | |
| 4 | Эх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах чиглэлээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад 43,000.0 мянган төгрөг, Хүний папиллома вирусийн халдварын эсрэг УХХХ-ын эрт илрүүлгийн хамрагдалтыг | 1 | 172,528.5 | | | 1 | 172,528.5 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахад 23,000.0 мянган төгрөг, Сувилагч тандаа баярлалаа" арга хэмжээний ажлын заал зохион байгуулалт, тайз засалт гэх арга хэмжээнд 109,528.5 мянган төгрөг, нийт 172,528.5 мянган төгрөгийг 8 компанитай шууд гэрээ байгуулж харьцуулалтын аргаас зайлсхийсэн байна. | | | | | | | | | | | | | |
| 5 | Тайлант онд сошиал медиа контент, подкаст, рийлс дүрс бичлэг хийлгэхээр "Лаён шийлд" ХХК-тай 6.600.0 мянган төгрөг, Монголын бизнес мэдээллийн судалгааны төвтэй 4,900.0 мянган төгрөг, Эко фокус ХХК-тай 4,900.0 мянган төгрөг, нийт 16,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээг дүгнэж акт үйлдээгүй, тайлангүй мөн Их тэнгэр ХХК-тай гэрээ байгуулаагүй 5,000.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 21,400.0 | | | 1 | 21,400.0 | | | | | | | |
| 6 | Тус яамны балансад бүртгэлгүй Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслийн 09-83 УКМ улсын дугаартай Toyota Land Cruiser-200 маркын автомашины тос масло солиход 509.6 мянган төгрөг, шинээр камер суурьлуулж хөгжим солиход 3,600.0 мянган төгрөг, нийт 4,109.6 мянган төгрөгийг зарцуулж, байгууллагын үйл ажиллагаанд явсан баримт байхгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан | 1 | 4,109.6 | 1 | 4,109.6 | | | | | | | | | |
| 7 | Ворлд гарден ХХК-тай 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр"бичиг хэргийн багц" худалдан авахаар 14,000.0 мянган төгрөгийн №13 дугаартай гэрээг байгуулж бараа материалын дансанд бичиг хэргийн багц нэрээр орлогод авч, 14 ажилтанд олгосноор баримт бүрдүүлсэн нь аудитын явцад зарим ажилтантай | 1 | 14,000.0 | | | 1 | 14,000.0 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ярилцлага хийхэд бичиг хэргийн материал биш жимс авсан байна. | | | | | | | | | | | | | |
| 8 | Тус байгууллага тайлант хугацаанд үйл ажиллагаанд зарцуулсан 141,591.2 мянган төгрөгийн бараа материалыг олгохдоо шаардах хуудсанд ахлах нягтлан бодогч, няравын гарын үсэг зурснаар зарлагдаж, санхүүгийн албаны дарга гарын үсэг зурж зөвшөөрөл олгохгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна. | 1 | 141,591.2 | | | 1 | 141,591.2 | | | | | | | |
| 9 | Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн ажилтан жолооч Б.Болдбаатартай сарын 1,500.0 мянган төгрөгийн хөлсөөр ажиллах гэрээ байгуулан жолоочоор ажиллуулж 1-6 сард нийт 7,249.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна. | 1 | 7,249.5 | | | 1 | 7,249.5 | | | | | | | |
| 10 | Жилийн эцэст 51,210.4 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Үүнээс Хүннү эйр компанид урьдчилж төлсөн 17,735.3 мянган төгрөг, Өдөр тутмын сонины сэтгүүлчдийн төлбөө ТББ-д шилжүүлсэн хэвлэл мэдээллийн зардлын урьдчилгаанд төлсөн 4,750.0 мянган төгрөг нийт 22,485.3 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. | 1 | 22,485.3 | 1 | 22,485.3 | | | | | | | | | |
| 11 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 48,205.2 мянган төгрөгийн хөрөнгө, 145,312.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. | 1 | 193,517.4 | | | 1 | 193,517.4 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Гэрэл цахилгааны зардал, тээвэр шатахууны зардал, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал, багаж техник хэрэгслийн зардал, урсгал засварын зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудаас нийт 180,766.1 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулан өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 180,766.1 | | | | | | | 1 | 1 | 180,766.1 | | |
| 13 | Тус байгууллага нь 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр "Саград" ХХК-иас "Дотоод аудитын мэргэжлийн нэр томьёоны тайлбар толь" ном 50 ширхэг, "Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ" ном 50 ширхэг, нийт 100 ширхэг номыг 4,480.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь зарцуулаагүй үлдэгдлээр бүртгэлтэй бөгөөд хэрэгцээгүй бараа материалын нөөц үүсгэсэн | 1 | 4,480.0 | | | | | 1 | 4,480.0 | | | | | |
| 14 | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал сэдэвт сургалтыг 8 сарын 15, 16-ны өдрүүдэд 80 албан хаагчийг хамруулан "Баянгол ресорт"-д зохион байгуулж сургалт болон хоол, танхимын түрээсийн зардалд нийт 30,475.4 мянган төгрөг, хувь хүнээр их цэвэрлэгээ хийлгэхэд 350.0 мянган төгрөг, төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулахад 6,439.5 мянган төгрөгийн хоолны зардал, төлж төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн. | 1 | 37,264.9 | | | 1 | 37,264.9 | | | | | | | |
| **Нийт дүн** | | **14.0** | **890,307.2** | **2.0** | **26,594.9** | **9.0** | **627,563.0** | **2.0** | **55,383.1** | **1.0** | **1.0** | **180,766.1** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 128,228.5 мянган төгрөгийн 7 мэдээлэл, тайлант оны худалдан авах ажиллагааны тайланг тус тус байршуулаагүй, мөн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | 128,228.5 | 1 | 128,228.5 | | |
| **Дүн** | | **1.00** | **128,228.50** | **1.00** | **128,228.50** | **-** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 47/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст он дамжсан 51,210,400.00 */тавин нэгэн сая хоёр зуун арван мянга дөрвөн зуу/* төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Үүнээс 2022 онд Хүннү эйр ХХК-д урьдчилж төлсөн 17,735,300.00 */арван долоон сая долоон зуун гучин таван мянга гурван зуу/* төгрөг, Өдөр тутмын сонины сэтгүүлчдийн төлөө ТББ-д хэвлэл мэдээллийн зардлын урьдчилгаанд төлсөн 4,750,000.00 */дөрвөн сая долоон зуун тавин мянга/* төгрөг, нийт 22,485,300.00 */хорин хоёр сая дөрвөн зуун наян таван мянга гурван зуу/* төгрөгийн төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Өмнөх онуудад билетийн урьдчилгаа төлбөрт төлсөн 17,735,300.00 */арван долоон сая долоон зуун гучин таван мянга гурван зуун/* төгрөгийг Хүннү эйр ХХК-аар, хэвлэл мэдээллийн зардалд төлсөн 4,750,000.00 */дөрвөн сая долоон зуун тавин мянган/* төгрөгийг Өдөр тутмын сонины сэтгүүлчдийн төлөө төрийн бус байгууллагаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 59/А017 1099 Улаанбаатар хот

САГ-2026/358/ИА-СТА-ТШ3

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны балансад бүртгэлгүй Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслийн 09-83 УКМ улсын дугаартай Toyota Land Cruiser-200 маркийн автомашины тос масло солиход 509,600.00 */таван зуун есөн мянга зургаан зуу/* төгрөг, шинээр камер суурилуулж хөгжим солиход 3,600,000.00 */гурван сая зургаан зуун мянга/* төгрөг, нийт 4,109,600.00 */дөрвөн сая нэг зуун есөн мянга зургаан зуу/* төгрөгийг зарцуулж, байгууллагын үйл ажиллагаанд явсан баримт байхгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.1.6-д "сахилга баттай байх" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Балансад бүртгэлгүй автомашинд олгосон шатахуун, сэлбэгийн үнэ 4,109,600.00 */дөрвөн сая нэг зуун есөн мянга зургаан зуу/* төгрөгийг Глобал сангийн дэмжлэгтэй дох сүрьеэгийн төслөөр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

9006199
АТА16587
9025381611

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 179/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СТА-ТСИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн яамны бүтэц орон тоонд байхгүй "сайдын ажлын албаны дарга" гэсэн албан тушаалд 2 иргэнтэй хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж нийт 17,658,852.00 /*арван долоон сая зургаан зуун тавин найман мянга найман зуун тавин хоёр*/ төгрөгийн цалин хөлсийг ажлын тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Монгол Улсын сайд өөрийн ажлын хэсэгтэй байж болно. Сайдын эрхлэх ажлын хүрээн дэх чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд сайдад зөвлөх үүрэгтэй сайдын зөвлөл ажиллана, сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам, сайдын ажлын хэсгийн орон тооны хязгаар, зардлын төсвийг Засгийн газар тогтооно", "Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан "Сайдын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийн тухай" 1-д "Монгол Улсын сайдын ажлын хэсэг нь сайдын зөвлөх, сайдын туслах, сайдын хэвлэлийн төлөөлөгч гэсэн 3-аас дээшгүй орон тоотой байхаар тогтоосугай" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн яамны бүтэц орон тоонд байхгүй "сайдын ажлын албаны дарга" гэсэн албан тушаалд хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ

АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ

АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 180/А0171099 Улаанбаатар хот

САТ-2026/358/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах чиглэлээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулахдаа ижил төрлийн 43,000,000.00 */дөчин гурван сая/* төгрөгийг 2 аж ахуйн нэгжтэй хэсэгчлэн хуваaж шууд гэрээ байгуулсан, Хүний папиллома вирусийн халдварын эсрэг урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахдаа 23,000,000.00 */хорин гурван сая/* төгрөгийг 1 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулсан, “Сувилагч тандаа баярлалаа" арга хэмжээний ажлын заал, тайз засалтын арга хэмжээг зохион байгуулахдаа 109,528,500.00 */нэг зуун есөн мянга таван зуун хорин найман мянга таван зуу/* төгрөгийг 5 аж ахуйн нэгжтэй хэсэгчлэн хуваaж шууд гэрээ байгуулан харьцуулалтын аргаас зайлсхийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваaж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-тай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д ”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт өртгийг хэсэгчлэн хуваaж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-22.Docx

15261S0409

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 181/А0171099 Улаанбаатар хот
САГ-2026/358/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сошиал медиа контент, подкаст, дүрс бичлэг хийлгэхээр "Лаён шийлд" ХХК-тай 6,600,000.00 */зургаан сая зургаан зуун мянга/* төгрөг, Монголын бизнес мэдээллийн судалгааны төвтэй 4,900,000.00 */дөрвөн сая есөн зуун мянга/* төгрөг, Эко фокус ХХК-тай 4,900,000.00 / *дөрвөн сая есөн зуун мянга/* төгрөгийн гэрээг тус тус байгуулж, гэрээг дүгнэж акт үйлдээгүй, ажлын тайлангүй санхүүжилтийг олгосон, мөн Их тэнгэр ХХК-тай гэрээ байгуулаагүй 5,000,000.00 */таван сая/* төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын тайлангүй, гэрээг дүгнээгүй санхүүжилтийг олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-22.Docx

1526189411

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 182/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ворлд гарден ХХК-тай 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр "Бичиг хэргийн багц" худалдан авахаар 14,000,000.00 */арван дөрвөн сая/* төгрөгийн №13 дугаартай гэрээг байгуулж хүнсний бүтээгдэхүүн авсан боловч бараа материалын дансанд бичиг хэргийн багц нэрээр орлогод авч, 14 ажилтанд олгосноор баримт бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", гэсэн заалтуудтай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-22.Docx*

1576199413

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 183/А0171099 Улаанбаатар хот
САГ-2026/358/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн ажилтан жолооч Б.Болдбаатартай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан жолоочоор ажиллуулж нийт 7,249,500.00 */долоон сая хоёр зуун дөчин есөн мянга таван зуу/* төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн ажилтантай давхар хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 05 өдөр    Дугаар 184/А0171099 САТ-2026/358/НА-СТА-ТШЗ    Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 48,205,200.00 */дөчин найман сая хоёр зуун таван мянган хоёр зуу/* төгрөгийн үндсэн хөрөнгө, 145,312,200.00 */нэг зуун дөчин таван сая гурван зуун арван хоёр мянга хоёр зуу/* төгрөгийн бараа материалыг худалдан авч өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусаагүй хөрөнгө, бараа материал бэлтгэж өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР    Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР    В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР    М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР    Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 185/А0171099 САГ-2026/358/НА-СТА-ТШЗ Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүй манлайлал сэдэвт сургалтыг 8 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд 80 албан хаагчийг хамруулан "Баянгол ресорт"-д зохион байгуулж сургалт болон хоол, танхимын түрээсийн зардалд 30,475,400.00 /*гучин сая дөрвөн зуун далан таван мянга дөрвөн зуу*/ төгрөг, хувь хүнээр их цэвэрлэгээ хийлгэхэд 350,000.00 /*гурван зуун тавин мянга*/ төгрөг, төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулахад хоолны зардалд 6,439,500.00 /*зургаан сая дөрвөн зуун гучин есөн мянга таван зуу*/ төгрөгийг тус тус төлж, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ

АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ

АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



1526189422

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 186/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 128,228,500.00 */нэг зуун хорин найман сая хоёр зуун хорин найман мянгө таван зуу/* төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй, мөн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, системд мэдээллийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-22.Docx

1526180424

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр — Дугаар 187/A0171099 — Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СГА-ТШ3

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/67 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж, Засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгүүлсэн үндэслэлээр санхүүгийн 9 ажилтанд нийт 22,352,600.00 */хорин хоёр сая гурван зуун тавин хоёр мянга зургаан зуу/* төгрөгийн урамшууллыг ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "Хууль тогтоомжид заасныг өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 188/А0171099 Улаанбаатар хот
САГ-2026/358/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд үйл ажиллагаанд зарцуулсан 141,591,218.00 */нэг зуун дөчин нэгэн сая таван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун арван найм/* төгрөгийн бараа материалыг олгохдоо шаардах хуудсанд ахлах нягтлан бодогч, няравын гарын үсэг зурснаар зарлагдаж, санхүүгийн албаны дарга гарын үсэг зурж зөвшөөрөл олгохгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Монгол Улсын Засгийн газрын “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 2025 оны 07 дугаар тогтоолын 16 дугаар хавсралтын 3-т “Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо,зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг” 3.3.3-т “Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг: Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд эрүүл мэндийн эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, цалин хөлсний бодлогын хэрэгжилтийг хангах, зохицуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах, эрүүл мэндийг дэмжих сан, гадаадын зээл, тусламжийн төсвийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх, нягтлан бодох бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хариуцах, салбарын хэмжээнд шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын үндэсний тооцоолол хийх, яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй.

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



1576180415

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээд шатны удирдлагын зөвшөөрөлгүй бараа материал зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Р.Содномцэрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 189/АД171099 Улаанбаатар хот

САГ-2026/358/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрэл цахилгааны зардал, тээвэр шатахууны зардал, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал, багаж техник хэрэгслийн зардал, урсгал засварын зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудаас нийт 180,766,100.00 */нэг зуун наян сая долоон зуун жаран зургаан мянга нэг зуу/* төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулан өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулан бодитой төлөвлөөгүй, батлагдсан төсвийн ангилал зөрчиж зарцуулсан зөрчлийг давтан гаргасан Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн Р.Содномцэрэнд хариуцлага тооцох, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*